

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН  
НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЭЛГЭН” НЭРТЭЙ  
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 1,2-Р БИЕТИЙН  
ХОЙД ХЭСГИЙГ ДАЛД УУРХАЙН АРГААР  
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**2024 он**

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	4
1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	5
1.2. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	10
2.ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	14
2.1.ЦАГ УУР, УУР АМЬСГАЛЫН ХҮЧИН ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	14
2.2.АГААР, АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ .....	14
2.3.УСНЫ НӨӨЦ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ .....	14
2.4.ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	15
2.5.УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ .....	15
2.6.АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ .....	16
2.7.ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ.....	16
3.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
3.1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
3.2.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
3.3.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ: .....	21
3.4.НҮҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ.....	21
3.5.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
3.6.ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
3.7.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	23
3.8.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
3.9.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
3.10. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ .....	26

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим .....	10
Хүснэгт 2. “Цагаан элгэн” ХХК-ийн үндсэн ба туслах тоног төхөөрөмжийн жагсаалт.....	11
Хүснэгт 3. Цаг уур, уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотой нөлөөлөл.....	14
Хүснэгт 4. Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	14
Хүснэгт 5. Усны нөөц, чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	14
Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	15
Хүснэгт 7. Ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	15
Хүснэгт 8. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	16
Хүснэгт 9. Нийгэм-эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл.....	16
Хүснэгт 10. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл.....	17
Хүснэгт 11. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал.....	18
Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	21
Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	21
<b>Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....</b>	<b>23</b>
Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	24
Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	25

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны хуваарь .....	5
Зураг 2. Төслийн талбай орчмын үнэмлэхүй өндөр .....	6
Зураг 3. Төслийн талбай орчмын газрын гадаргын налуу .....	6
Зураг 4. Төслийн талбай орчмын газрын гадаргын ерөнхий төрх (хойд хэсэг) .....	7
Зураг 5. Төслийн талбай орчмын газрын гадаргын ерөнхий төрх (урд хэсэг).....	7
Зураг 6. Техник тоног төхөөрөмжийн сонголтууд .....	13

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Цагаан элгэн” ХХК-ийн эзэмшдэг MV-011981 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан элгэн хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших ба 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн L-49-63 тоот хавтгайд орших бөгөөд 30.11 гектар талбайг хамарна.


### Ерөнхий мэдээлэл

- |   |  |
|---|--|
| <i>Төслийн нэр</i>  | ▪ “Цагаан элгэн хайлуур жоншны хүдрийн 1,2-р биетийн хойд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах” төсөл   |
| <i>Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:</i> | ▪ “Цагаан элгэн” ХХК<br>- Улсын бүртгэлийн дугаар: 9019010042<br>- Регистрийн дугаар: 5053722  |
| <i>Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:</i>                        | ▪ Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 53, 5 тоот<br>▪ Утас: 976-99114029  |
| <i>Төслийн ангилал</i>                                    | ▪ Байгаль орчинд нөлөөлөл байдлын үнэлгээний тухай хуулийн хавсралтын дагуу Уул уурхайн төсөл ангилалд хамаарна  |
| <i>Төслийн зорилго, үйл ажиллагаа:</i>                    | ▪ Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаан элгэний MV-011981 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан уг ордыг ашиглах төсөл боловсруулан ордыг аж ахуйн эргэлтэд оруулж улс орны төсөвт өөрийн хувь нэмрээ оруулах, шинээр ажлын байр бий болгох, уул уурхайн салбарыг хөгжүүлэх зэрэгт оршино. |
| <i>Төслийн үргэлжлэх хугацаа</i>                          | ▪ 6 жил  |

### Төслийн байршил

MV-011981 тоот ашиглалтын талбай нь засаг захиргааны хувьд Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Улаанбаатар хотоос 420 км, Борөндөрийн УБҮйлдвэрээс зүүн урагш 90 км зайд байрлана.

“Цагаан элгэний хайлуур жонш”-ны ордын талбай нь ашигт малтмал ашиглалтын MV-011981 тоот тусгай зөвшөөрөлтэй 30.11 гектар талбайг хамардаг.



Зураг 1. Засаг захиргааны хуваарь


### 1.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

**Газарзүйн мужлал, газрын гадаргуу:** Иххэт сумын нутаг дэвсгэр нь Монгол орны Физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их муж, Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт хамаарна. Энэ муж нь Хангай-Хэнтийн их мужийн зүүн хэсгийн урдуур Төхөм нуур хавиас эхлэн Чойбалсан хот хүртэл үргэлжлэхдээ зүүн тийшээ өргөсөн зүүн зах нь дорнод уртрагийн бараг 117 хүрч их хэмжээний газрыг хамарна. Энэ нутаг нийтдээ талархаг гадаргатай бөгөөд ухаа гүвээт тал зонхилно. Тал газар нь тус мужийн бараг ихэнх хагасат тархсан ба ухаа гүвээнүүд харьцах өндрөөрөө хэдхэн арван метр байхаас гадна хажуу нь маш налуу, орой нь ялихгүй бөмбөгөр хэлбэртэй байна. Хааяа хажууд нь буюу оройд нь үндсэн чулуулгийн хад ил гарна, тэдгээрийн хооронд жижиг хотос буюу тэгш гадарга оршино. Тэнд 3-аримдаа жижиг нуур тогтох юм уу хужир марц үүссэн байна. Энэ муж дотор тод ялгарч буй 3 тойрогтой. Үүнд: Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт, Дорнод хотгор, Дарьгангын талархаг газар байна. Төслийн талбайн район нь Халхын дундад ухаа гүвээт талын тойрогт хамаарах бөгөөд ухаа гүвээт тал зонхилж, уулс тэнд, энд ганц нэгээр оршино. Тойргийн үнэмлэхүй өндөр 900-1700 метр болно.


**Уул зүй.** Судалгааны талбайн дийлэнх хэсгийг уул зүйн ангиллаар 1000-1500 м өндөршилтэй өндөрлөг тал буюу жижиг толгодлог гадаргуу, бусад хэсгийг 1000 м-ээс доош үнэмлэхүй өндөршилтэй намдуу талын хэв шинжид хамаарах Өмнөд Хэнтийн хуримтлалын гадаргуу эзэлнэ. Талбайн орчимд хамгийн өндөр цэг нь Зүүн мандлын овоо (1321.9 м), Бор-Өндөр уул (1279.7 м), хамгийн нам цэг нь Хонхор худаг (1014.0 м) байна. Гадаргын хэрчигдлийн нягтшилын хувьд голдирол болон нам доор газрын хоорондын дундаж зай 1300-1100 м хүртэл хэлбэлзэх ба гадаргын хэрчигдлийн гүн Монгол орны хамгийн нам цэг Хөх нуурын хотгортой харьцуулахад 200 м-ээс бага 200-400 м, 400-600 м хүртэл өндөршилтэй байна. Талбайн усан хагалбар болох нам уулс, гүвээ нь өргөргийн дагуу чиглэлтэй урт, нарийн сунасан тогтоцтой бөгөөд энэ нь тухайн районы тектоник эвдрэлийн чигтэй давхацдаг. Чулуулгийн илэрц дунд зэрэг, харин талбайн баруун урд талаар триасын бор-өндрийн комплексын гүний бүрдлийн чулуулгийн гаршууд сайтар илэрдэг бөгөөд бусад

газарт дээрх насны чулуулгаас тогтсон жижиг толгод, гүвээнүүдийн орой хэсгээр гарш сайтай байдаг.

Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1132 – 1180 метрийн өндөрт байрласан ба газрын гадаргын налуужилт 3.45-4.76 (градуст) байрласан байна.



Зураг 2. Төслийн талбай орчмын үнэмлэхүй өндөр



Зураг 3. Төслийн талбай орчмын газрын гадаргын налуу

Газрын гадаргын эвдрэл, өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдал. Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших “Цагаан-Элгэн” ХХК-ийн “Цагаан элгэний хайлуур жоншны орд” төслийн талбай нь нийт 30.11 га талбайг хамарна. Уурхайн үйл ажиллагаанаас буюу хөрсний овоолго, асгасан шороо болон уурхайн замын нөлөөгөөр 6.87 га талбай эвдрэлд өртсөн байна.



Зураг 4. Төслийн талбай орчмын газрын гадаргын ерөнхий төрх (хойд хэсэг)



Зураг 5. Төслийн талбай орчмын газрын гадаргын ерөнхий төрх (урд хэсэг)

**Уур амьсгал:** Районы цаг уур эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн болон хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, жилийн дундаж хэм нь  $-50^{\circ}\text{C}$ . Хамгийн хүйтэн үе нь 12-р сараас 2 сарын эхэн байдаг ба  $-28.50^{\circ}\text{C}$ -ээс  $-32.90^{\circ}\text{C}$  хүртэл хүйтэрдэг бөгөөд хамгийн халуун

сар нь 7-8-р сар, +230С-ээс +330С-ийн дулаантай байдаг. Жилийн хур тунадасны хэмжээ 101мм - 343мм-т хэлбэлздэг ба улирал бүрд харилцан адилгүй буудаг. Үүний 70-85% нь зуны улиралд бороо хэлбэрээр буудаг, Өвөлд 10-20 мм-ээс хэтрэхгүй цас ордог, цасан бүрхэвчийн зузаан 5-8 см боловч зарим жилийн өвөлд цас ороогүй тохиолдол цөөнгүй тохиолддог. Анхны цас 10-11 сарын үед ордог ба 3-р сард хайлж дуусдаг. Агаарын чийгшилт зундаа 46-68%, харин өвөлдөө 60-85%-д хэлбэлздэг. Өвөлдөө хүйтэн боловч хур тундасгүй нарлаг цаг агаар зонхилдог, хавартаа ч мөн адил боловч салхи шуурга ихтэй байдаг. Хүйтний улиралд хөрсний хөлдөлт гадаргуугаас дунджаар 2-2.5 м, олон жилийн цэвдэг байхгүй. Хавар цагт бараг тогтмол салхи шуургатай байдаг ба салхины хурд дунджаар 4.7 м/сек гэх боловч зарим үед 14-18 м/сек, үе үе 20-24м/сек хүрч хүчтэй цасан болон шороон шуурга тавьдаг. Салхины чиглэл голдуу баруун хойноос зүүн урагш чиглэлтэй байдаг. Зуны ихэнх нь аагим халуун, харин сүүл рүүгээ бага зэрэг сэрүүсч, бороо хур элбэгшдэг. Намартаа сэрүүн салхитай, нарлаг өдрүүд болж, шөнөдөө хасах хэмтэй, өдөртөө дулаан цаг агаар зонхилдог. Дорноговь аймгийн зүүн хойд нутгийн хэсгээр орох нийт хур тунадасны дундаж хэмжээ 100-120 мм байна. Нийт хур тунадасны ихэнх хувь нь дулааны улиралд ордог. 11-3 дугаар саруудын хооронд орох хур тунадасны хэмжээ дунджаар 5 мм байхад 4-10 дугаар саруудад орох хур тунадасны хэмжээ 108 мм байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн цаг уурт өөрчлөлт орж байгаатай уялдан зундаа маш их халуун (+40)-(+50<sup>0</sup>С), өвөлдөө маш хүйтэн (-40)-(-50<sup>0</sup>С) хүрэх явдал ажиглагдаж байна.

**Газрын доорх ус:** Төслийн талбай нь гарын доорхи уст давхарга бүрдлийн хувьд янз бүрийн настай, тунамал, бялхмал, хувирмал чулуулаг дахь бага бүрдэлтэй уст бүрдэлд багтана. гидрогеологийн мужлалаар газрын доорх усны тэжээлийн горимоор улирлын дунд зэрэг тэжээлтэй мужид, Дорноговийн дэд мужид тус тус хамрагдана. Усжилт ихтэй тектоник хагарлын бүсүүд нь өндөр бус усжилттай чулуулгийн фон дээр ялгагддаг. Энэ фон дээр цооногийн хувийн ундарга 0.2 л/сек-с хэтрэхгүй, харин тектоник хагарлын бүсүүдэд 0.3-7.7 л/сек хүрдэг. Гидрогеологийн үзүүлэлтийн зүй тогтлоор өсч буй нь ажиглагддаг. Бүхэлдээ хайлуур жоншны ордын усжилт сулавтар болно. Тусгай зөвшөөрлийн талбайн орчимд усан сүлжээ муутай, хуурай уур амьсгал зонхилдог тул нуур, цөөрөм, горхи, булаг бараг байдаггүй. Хаврын цас хайлалтын үед талбайн орчимд толгод хоорондын жижиг хонхруудад жижиг цөөрөм шалбааг тогтдог, малтагдсан худаг байдаггүй. Газрын доорх усны түвшин 30-40 м гүнд байдаг нь судалгааны малталтуудын үед илэрсэн. Гидрогеологийн нөхцөлийн хувьд орд нь сулавтар усжсанд хамаарагдах ба цооног дахь усны ундарга 0.08-0.3 л/сек, ус нь даралтгүй байна. Орд газрыг ашиглахад ус нэвчилт, хуурайшилт зэрэг ямар нэг гидрогеологийн хүндрэл учрахгүй, өөрөөр хэлбэл гидрогеологийн таатай нөхцөлтэй юм.

**Гадаргын усны нөөц, горим, шинж чанар:** Төслийн талбай нь Төв азийн гадагш урсацгүй ай савд хамаарна. Монгол орны усны сав газрын ангиллаар Умард говийн гүвээт-Халхын сав газарт хамаарах бөгөөд Хэрлэн голын сав газрын хилтэй ойр оршино. Энэ сав газар нь хэдийгээр газар нутгийн хувьд өргөн уудам нутаг дэвсгэрийг хамардаг ч гадаргын усны нөөц маш багатай, жижиг гол, горхи, булаг, шанд, түр зуурын урсацтай сайр, хур тунадасны усаар ихэвчлэн тэжээгддэг жижиг нуур, тойрмуудаас бүрдэнэ. Сав газрын ус хураах талбай 180404.2 км<sup>2</sup>. Сав газрын дундаж урсцын модуль хойд хэсгээрээ 1л/с км<sup>2</sup> хүрэх ба сав газрын ихэнх хэсгээр 0.6л/с км<sup>2</sup>, түүнээс бага байна. Тус сав газар нь усны нөөцийн ангиллаар газрын доорх усны нөөцтэй ангилалд хамаардаг. Умард говийн усны сав газрын хүрээнд гадаргын усны нөөц хомс тул сав газар дахь жижиг нуур, тойром, гол горхиудад ус судлалын байнгын харуул бүхий ажиглалт, хэмжилтийн сүлжээ байхгүй. Сав газрын гадаргын усны сүлжээний нягтшил буюу 1км<sup>2</sup> талбайд ногдох голын урт нь маш бага (0.01км/км<sup>2</sup>) бөгөөд сав газрын хэмжээнд хамгийн их урсац бүрдэлт нь сав газрын хойд, баруун хойд хэсэгт ажиглагдана. Улсын усны нэгдсэн тооллогын дүнгээр сав газрын хэмжээнд Дорноговь аймгийн Иххэт суманд 10 булаг тоологдсон байна. Төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр орших гадаргын ус нь Даргайт булаг бөгөөд төслийн талбайгаас зүүн урд зүгт 14 км зайд байрлана.



**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн цайвар хүрэн хөрсний дэд бүс, Баяндэлгэрийн тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Толгодын хүрэн хөрс нь далайн түвшнээс дээш 1132-1180 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан толгодорхог тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгийн 1.04-4.76 (градус) байна. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж (MNS 5850:2019) стандарттай харьцуулахад хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага байгаа нь химийн бохирдолгүй байна. Мөн хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна. Уурхайн үйл ажиллагаанаас буюу хөрсний овоолго, асгасан шороо болон уурхайн замын нөлөөгөөр 6.87 га талбай эвдрэлд өртсөн байна.

**Ургамлан нөмрөг:** Төслийн талбай, түүний орчмын газар нутаг нь Монгол орны ургамал-газарзүй нь мужлалаар Евразийн хээрийн их муж Төд азийн дэд муж Алтанширээгийн тойрогт хамаарна (Монгол Улсын үндэсний атлас, 2009). Төсөл хэрэгжих талбай нь Ургамал-газарзүйн тойргоор Дундад Халхын дүүрэгт хамаарагдана (В.И.Грубов, 1955). Төслийн талбайд бүйлс, чулуурхаг хялгана, алаг өвст ургамлан нөмрөг тархсан байна. Судалгаа гүйцэтгэсэн талбайн эргэн тойронд ургамал нөмрөг харьцангуй сийрэг, чулуусаг, зарим хэсгээрээ элсээр бүрхэгдсэн жилийн 4 улиралд ашиглаж байсан бэлчээр нутаг байсан ба ургамлын ерөнхий тусгаг бүрхэц нь 16,6% , ургамлын дундаж өндөр 9 см, аж ахуйн бүлгээрээ үетэн, шарилж, улалж бүлгийн ургамлууд зонхилж байна.

**Амьтны аймаг:** Төсөл хэрэгжих нутаг нь Дорнод говийн тойрог, Монгол Дагуурын тойргуудын заагт хамаарах учир говь, цөлөрхөг хээрийн бүсийн бионт зонхилж байна. Тус төсөл хэрэгжих талбай нь хүн амын суурьшил харьцангуй бага (Иххэт сумаас 6 орчим км) боловч уул уурхайн нөлөөлөлд өртсөн талбайтай зэргэлдээ оршиж байгаа учир том хөхтөн амьтад амьдрах орчноосоо дайжих шалтгаан болжээ. Гэвч улирлын чанартай цагаан зээр нүүдлэн ордог бол аргаль хонь цөөн тохиолдоно. Харин нүүдлийн шувууд дайран өнгөрөх боломжтой. Өмнөх судлаачдын мэдээ баримт болон бидний хайгуул судалгаагаар уг талбайд цагаан зээр, аргаль хониноос өөр ховор болон ховордсон зүйлүүд тэмдэглэгдээгүй байна. Нутгийн иргэдийн аман мэдээнээс үзэхэд мөлхөгчдөөс рашааны могой, бамбай хоншоорт могой цөөн тохиолддог бол цоохор хонин гүрвэл элбэг, хөхтөн амьтаас бор туулай, дэлдэн зараа, морин чичүүл элбэг тохиолддог бол хярс зэрэг махчид цөөн ажиглагддаг байна. Мөн шувуудын хувьд хот суурин газар шүтэн амьдардаг зүйлүүд тохиолддог байна.

**Хүн ам, зам харилцаа, дэд бүтэц:** Тухайн районд хүн ам сийрэг 1 кв.км талбайд 0.2-0.6 хүн ам ноогддог. Хамгийн олон хүнтэй нь Иххэт сум болон Бор-Өндөрийн хайлуур жоншны УБҮ-ийн тосгон 15000-20000 хүн амтай ба ихэнх нь халх үндэстэн байдаг. Цагаан-Элгэний хайлуур жоншны ордын 3-р хүдрийн биет нь Улаанбаатар хотоос зүүн урагш 390 км зайд байрлана. Иххэт сум болон Бор Өндөр тосгонд эмнэлэг, шуудан холбоо, цахилгаан станц, дэлгүүр хоршоо, зочид буудал, халуун ус зэрэг нийтийн үйлчилгээний газрууд байдаг. Хүн амын ихэнх нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг. Улаанбаатар хотоос Говьсүмбэр аймгийн төв Чойр хүртэл 223 км асфальтан засмал замаар, түүнээс цааш Цагаан-Элгэний орд хүртэл ердийн шороон замаар холбогддог ба эдгээр замуудаар жилийн аль ч улиралд ямар ч тээврийн хэрэгсэл саадгүй зорчих боломжтой.

**Цахилгаан хангамж:** Иххэт сумаас Галшар сум хүртэлх 35кВ-н шугамаас уурхай руу татагдсан шугам уурхайгаас 6км зайтай байрладаг тул уг шугамаас салбарлуулан 6км урттай 35кВ-н агаарын шугамыг 35/10кВ-н шугам уурхай руу татан гадаад цахилгаан хангамжийг авч уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцоолов.

**Усан хангамж:** Унд ахуйн хэрэгцээт усыг тус ордоос урд зүгт 0.3 км зайд байрлах Төвшин ХХК-ийн гар худгаас хангана. Гар худгийн ундарга нь дунджаар 1.2 л/с байна.

## 1.2. Төслийн товч тодорхойлолт

АМГТГ-ын 2007 оны 01-р сарын 29-ны өдөр олгосон MV-011981 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэн үр дүнгийн тайлан боловсруулж хүдрийн 1-р биетийн геологийн нөөцийг В+С1 зэргээр 449.5 мян.тн-оор, 2-р хүдрийн биетийн геологийн нөөцийг С1 зэргээр 176.1 мян.тн-оор тус тус тооцож улсын бүртгэлд бүртгүүлжээ.

MV-011981 тоот ашиглалтын талбайд хамаарах нөөц 1-р хүдрийн биет дээр 202.2 мян.тн хүдэр буйгаас 16.4 мян.тн хүдэр олборлож 2019 оны 9-р сарын 1-ний байдлаар 185.8 мян.тн хүдэр үлдсэн байна. Харин 2-р хүдрийн биет дээр 31.99 мян.тн хүдэр буйгаас 2.5 мян.тн хүдэр олборлож 2019 оны 9-р сарын 1-ний байдлаар 29.5 мян.тн хүдэр тус тус үлдсэн байна.

Дээрх нөөцөд тулгуурлан ТЭЗҮ-г ЭБЭХ-ний Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу “Эрдэнэс инженеринг” ХХК боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Т/20-06-01 тоот дүгнэлтээр баталгаажуулсан байна.

### 1.2.1. Хүчин чадал, ажиллах горим

Далд уурхайн жилийн хүчин чадлыг жилд дунджаар хүдрээр 40.0 мян.тн хүдэр олборлохоор тооцжээ.

**Далд уурхайн ажиллах горим:** Уулын ажлыг газрын дор ажиллах далд уурхайн хэсэгт 8 цагийн үргэлжлэлтэй 3 ээлжээр сонгосон байна.

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим

№	Уурхайн ажиллах горим	
1	Жилийн хуанлин өдөр	365 хоног
2	Ажиллах нийт хоног	330 хоног
3	Баяр ёслолын үеийн амралтын өдөр	11 хоног
4	Засвар үйлчилгээ хийх өдөр	24 хоног
5	Нэг хоног дахь ээлжийн тоо	3
6	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	8 цаг

**Ашиглалтын систем:** Ашиглалтын системийг сонгон авахад уул-техникийн нөхцөл хүдрийн биетийн зузаан, уналын өнцөг, тааз ба улны чулуулгийн тогтоц, бат бөхийн хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх, хүдэр олборлолтын зардал хамгийн бага, хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр зэрэг үзүүлэлтүүд ихээхэн нөлөөлдөг. Геологи хайгуулын ажлаар тодорхойлогдсон хүдрийн биетийн үндсэн үзүүлэлтүүдийг үндэслэн Цагаан элгэний хүдрийн 1, 2-р биетийг шпурын цэнэгийн аргаар хоршоолон нураах ашиглалтын системээр олборлохоор ТЭЗҮ-д тооцсон байна.

### 1.2.2. Ашиглалт явуулах уул техникийн нөхцөл

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул хийгдсэн Цагаан элгэний хүдрийн 2 биет байрлах бөгөөд хүдрийн биетийн урт 600-1000 м хүртэл урт сунаж тогтсон. Хүдрийн биетүүд нь В+С нөөцийн хувьд гадаргуугаас 130 метр орчим гүнд судлагдсан байна.

Биетүүд газрын гадаргууд суналын дагуу илэрч рельефийн хувьд бага зэрэг өргөгдсөн хэлбэртэй. Хүдрийн биетийн урт 600-1000 м, дундаж зузаан 1.8 м, суналын чиг зүүн урагш 130-150°, уналын өнцөг 70-75°, гүндээ 130 метр орчим үргэлжилнэ. Ордын хүдрийн эзлэхүүн

жин нь 2.62 тн/м<sup>3</sup>, чулуулгийн бат бэхийн коэффициент проф.Протодьякновын ангиллаар агуулагч чулуулагт f=12, хүдрийн хувьд f=12-13 байна.

Агуулагч чулуулгийн хувийн жин 2.5-2.6 кг/см<sup>3</sup> хүртэл хэлбэлзэнэ. Сийрэгжилтийн коэффициент 1.3-1.38. Агуулагч чулуулгийг ерөнхий байдлаар тогтворжилттой гэж үзэж болох ба зөвхөн зарим хэсэгт дунд зэргийн тогтворжилттой байна.

Цагаан элгэний хайлуур жоншны хүдрийн 2 биет байх бөгөөд эдийн засгийн үр ашигтай байдлыг бодолцон далд уурхайн аргаар олборлохоор төслийг боловсрууллаа.

### 1.2.3. Далд уурхайн ашиглалтын нөөцийн тооцоо

**Хаягдал, бохирдол.** Хүдэр олборлох үеийн хаягдал бохирдлыг дор тодорхойлов. Үүнд:

- **Хаягдал.** Хүдэр олборлолтын үед дараах хаягдал гарахаар тооцлоо. Үүнд 1-р хүдрийн биет дээр хамгаалалтын цулд нийт 1266 м<sup>3</sup>, таазанд үлдэх хамгаалалтын цулд 3751 м<sup>3</sup>, хүдэр нураалтын үед 706 м<sup>3</sup> хүдэр тус тус хаягдах ба нийт 5724 м<sup>3</sup>, буюу 15109 тн, нийт хүдрийн 8.13 %, харин 2-р хүдрийн биет дээр хамгаалалтын цулд нийт 201 м<sup>3</sup>, таазанд үлдэх хамгаалалтын цулд 1324 м<sup>3</sup>, хүдэр нураалтын үед 111.8 м<sup>3</sup> хүдэр тус тус хаягдах ба нийт 1637 м<sup>3</sup>, буюу 4315 тн, нийт хүдрийн 14.63 % хаягдахаар тус тус тооцлоо.
- **Бохирдол.** Хүдэр олборлолтын явцад хүдрийн биетийн ул таазнаас тус бүр 0.1 м зузаантайгаар бохирдуулж авна. Ингэхэд ашиглалтын үеийн бохирдол нь 1-р хүдрийн биет дээр 20324.0 тн, нийт 10.94 %, 2-р хүдрийн биет дээр 3398 тн, нийт 11.52 % болж байна.

### 1.2.4. Тоног төхөөрөмжийн сонголт

Уулын үйлдвэрлэлийн ажилд шаардлагатай үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг дараах байдлаар сонгосон байна. Уулын малталт болон хүдэр нуураалтын ажилд өрөмдлөг хийхэд БНХАУ-д үйлдвэрлэсэн ҮТ-28 маркийн гар перфоратор бш, малталт нэвтрэлт болон хүдэр олборлолтын үед ачилтын ортуудаас уулын цулыг тэргэнцэрт ачих зориулалтаар Z-20W маркийн ачигч машин 2ш, уулын цулыг тээвэрлэх УВО – 0.8 маркийн тэргэнцэр 4ш, Уулын цулыг тээвэрлэх тэргэнцрийг чирэх 4.5 АРП-2М маркийн цахилгаан зүтгүүр 1ш, босоо гол ам нэвтрэх үед өргөлтийн ажилд ачаа тээх 0.8 м<sup>3</sup> багтаамж бүхий бадъя ашиглахаар сонголоо.

Хүснэгт 2. “Цагаан элгэн” ХХК-ийн үндсэн ба туслах тоног төхөөрөмжийн жагсаалт

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр төрөл	Марк	Үйлдвэрлэсэн улс	Тоон үзүүлэлт, хэмжих нэгж	Тоо, ширхэг	
1	Далд уурхайд	Өрөмдлөг тэсэлгээний ажилд				6
		Гар перфоратор	ҮТ-28	БНХАУ	11.0 м <sup>3</sup>	
		Ухаж ачих, тээвэрлэх				
		Ачигч машин	Z-20W	БНХАУ	0.2 м <sup>3</sup>	
		Тэргэнцэр	УВО – 0.8	БНХАУ	0.8 м <sup>3</sup>	
4	Цахилгаан зүтгүүр	4.5 АРП-2М	БНХАУ	0.8 м <sup>3</sup>	1	
5	Өргөх байгууламж	JK2.5/30А	БНХАУ	0.8 м <sup>3</sup>	1	
Далд уурхайд хэрэглэх нийт тоног төхөөрөмж					14 ш	
1	Бутлан ангилах, гар аргаар ялгах хэсэг	Чичиргээт тэжээгүүр	CZD700*1800	БНХАУ	20-80 тн/цаг	1
2		Хацарт бутлуур	PE400*600	БНХАУ	10-35тн/цаг	1
3		Туузан дамжуулагч	TD75-500	БНХАУ	15-20м <sup>3</sup> /цаг	2
4		Доргиурт шигшүүр	SZZ1000*2200		4.5-90тн/цаг	1
Бутлан ангилах, гар аргаар ялгах хэсэг					5	

5	Тээвэрт	Автосомасвал	HOWO	БНХАУ	10.3 м <sup>3</sup>	1
6		Утгуурт ачигч	ZL-50	БНХАУ	3.0 м <sup>3</sup>	1
Нийт хэрэглээ						2



YT-28 маркийн гар өрмийн машин



Z-20W маркийн ачигч машин



УВО – 0.8 маркийн тэргэнцэр



4.5 АРП-2М маркийн зүтгүүр



JK2.5/30A маркийн өргөх байгууламж



1YKH-1.55-1 маркийн клеть



HOWO маркийн автосомасвал



ZL-50 маркийн утгуурт ачигч



CZD700\*1800 маркийн чичиргээт тэжээгүүр



PE400\*600 маркийн хацарт бутлуур



TD75-500 маркийн туузан дамжуулагч



SZZ1000\*2200 маркийн доргиурт шигшүүр

Зураг 6. Техник тоног төхөөрөмжийн сонголтууд

### 1.2.5.Эдийн засгийн үзүүлэлт

Уурхайг ажиллуулахад нийт 2819.97 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс ялгах хэсгийн хөрөнгө оруулалт 162.8 сая.төгрөг, уурхайн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 1265 сая, уурхайн цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалт 445.9 сая, дэд бүтэц барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 200.6 сая төгрөг, биет бус хөрөнгө бэлтгэл ажлын зардалд 441.3 сая, уурхайн машин техник 304.5 сая төгрөг тус тус шаардлагатай байна

## 2.ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг доорх хүснэгтээр харууллаа.

### 2.1.Цаг уур, уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хүснэгт 3. Цаг уур, уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотой нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Төслийн үйл ажиллагаанаас орчны бичил уур амьсгалд учруулах сөрөг нөлөөлөл		+			
Хэт халалтаас ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл		+			
Температурын өөрчлөлтөөс ажлын горимд нөлөөлөх нөлөөлөл		+			
Аянга цахилгааны үйлчлэлээс үүсэх нөлөөлөл		+			
Аадар бороо, үерээс үүдэлтэйгээр үүсэх сөрөг нөлөөлөл		+			
Хүчтэй салхи, шуурганаас үүсэх нөлөөлөл		+			

Болзошгүй нөлөөллийн 87.5 хувь нь “бага”, 12.5 хувь нь “дунд” нөлөөтэй байгаа тул уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг “бага” гэж үзэж болохоор байна.

### 2.2.Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө

Агаарын чанарт хөрс хуулах, засварын талбай дэд бүтэцийн хэсгээс сөрөг нөлөөлөл үүсэхээр байна. Энэ нь хөрс хуулах, хөрс овоолго, гадаад болон дотоод тээвэр хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт болон тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн дутуу шаталтаас үүсэх хийн хаягдал байна.

Хүснэгт 4. Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Барилга байгууламжийн ажлын үед хөрс хуулах, элс хайргаар хучилт хийх, нягтаршуулах ажлын үед нарийн ширхэглэгт хэсгүүд агаарт дэгдэн тоосжилт үүсгэх		+			
Төслийн үйл ажиллагааны үед ашиглагдах том оврын тээврийн хэрэгсэл, техникуудийн хөдөлгүүрээс хийн хаягдал ялгарч агаар орчныг бохирдуулах		+			
Хог хаягдлыг шатааж устгах нөхцөлд хортой хий ялгарч, агаарын бохирдол үүсгэх		+			

Агаарт учруулж болзошгүй нийт нөлөөллийн 66.6 хувь нь “бага”, 33.3 хувь нь “дунд” зэргийн нөлөөлөл байна. Агаар орчныг бохирдуулах гол эх үүсвэр нь тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах хийн хаягдал болон замын хучилтыг хийх үед үүсэх тоосжилт байхаар байна.

### 2.3.Усны нөөц чанарт үзүүлэх сөрөг нөлөө

Гол сөрөг нөлөөлөл нь баяжуулах хэсгийн ус ашиглалтын улмаас газрын доорх усны нөөц багасах, Нарангийн голын тэжээмж буурах магадлалтай юм. Мөн техникийн тос масло хөрсөнд алдвал газрын доорх усыг, цаашлаад гадаргын усыг бохирдуулж болзошгүй.

Хүснэгт 5. Усны нөөц, чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Унд ахуйд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны хөөц хомсдох		+			
Гадаргын болон газрын доорх ус бохирдох		+			
Ахуйн хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усыг бохирдуулах		+			
Гадаргын болон газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэхэд 33.3 хувь дунд, 66.7 хувь "бага" нөлөөлөлтэй байна.					

#### 2.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Уурхайн барилга байгууламж, засварын талбай барих хэмжээгээр хөрсөн бүрхэвч бүрэн устахаас гадна тээврийн хэрэгслийн зам талбай нь нөлөөлөлд өртөнө. Мөн хог хаягдал хөрсөн бүрхэвчийг бохирдуулах, олон салаа зам гарган талхагдалд оруулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй юм.

Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Уурхайд ашиглалт явуулах талбайн хэмжээгээр хөрс эвдрэлд өртөх		+			
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэн хөрс эвдрэх		+			
Ахуйн болон бусад хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрс бохирдох		+			
Барилга, байгууламжийн ажилд ашиглах элс хайрганы кареарын талбайн хэмжээгээр үржил шимт хөрс нөлөөлөлд өртөх		+			
Уурхайн ажилчдын байрлах кемпийн орчим хөрс элэгдэл, эвдрэлд өртөх		+			
Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн 80 хувь нь дунд зэрэг, 20 хувь нь бага зэргийн нөлөөлөл байна. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уурхайн барилга байгууламжийг барих үед болон олборлолтын ажлын үед үүсгэн хөрс, ургамал нөлөөлөлд өртөх, уурхайн болон ажилчдын тээврийн хэрэгслүүд олон салаа зам гарган хөрс ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлнө. Мөн ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаясанаар хөрс, ургамлыг бохирдуулах болзошгүй юм.					

#### 2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө

Төслийн бүхий л шатны үйл ажиллагаанаас ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн их байна. Үүнээс гадна хатуу шингэн хог хаягдлыг ил задгай хаях, олон салаа зам гаргах, тоосжилт ихээр үүсгэх зэргээр ургамалан нөмрөгийг талхагдалд оруулах, фотосинтезийн эрчмийг бууруулах сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй юм.

Хүснэгт 7. Ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Талбайн эрүүл газрын хөрсийг хөндөх тул ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлнө.		+			
Тээврийн хэрэгслийн олон салаа зам гарган ургамлан нөмрөгийг талхагдалд оруулах		+			
Барилгын ажилд ашиглах карьер ашиглалтын хэмжээгээр ургамлан нөмрөг устаж болзошгүй		+			
Ургамалан нөмрөг тоосонд дарагдаж		+			

бохирдсоноос ургах чадвар нь буурах					
Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамалан нөмрөгийг гэмтээх, бохирдуулах		+			
Ажилчдын ахуйн шингэн болон хатуу хог хаягдлаар ургамлан нөмрөг бохирдох улмаар ургах чадвараа алдах		+			
Нийт нөлөөллийг авч үзэхэд төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх нийт сөрөг нөлөөллийн 50 хувь нь бага, 50 хувь нь дунд зэргийн сөрөг нөлөөлөл байна.					

## 2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөө

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх шууд сөрөг нөлөөлөлгүй бөгөөд төслийг хүчин чадлаас хэтрүүлэн ажиллах, их хэмжээний давтамж бүхий дуу чимээ үүсгэх, олборлолтын үйл ажиллагаа зэрэгт хаалт хашилт хийгээгүйн улмаас мал, амьтан унаж бэртэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй байна.

Хүснэгт 8. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар				
	Нөлөөлөлгүй	Бага	Дунд	Их	Хүчтэй
Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх		+			
Бохирдсон өвс ургамлыг мал, амьтан идэж хордох		+			
Бохирдсон ус ууснаас мал, амьтан хордох		+			
Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх		+			
Ухсан нүх, эрэг рүү мал, амьтан унаж бэртэх		+			
Нийт нөлөөллийн 60% нь бага, 40% нь дунд зэргийн нөлөөлөл үүсэх болзошгүй байна. Төслөөс бий болох болзошгүй нөлөөлөл нь карьерийн цооног, нүх, ухааш зэрэгт мал, амьтан унаж бэртэх, дуу чимээнээс зэрлэг ан амьтад үргэж дайжих зэрэг нөлөөллүүд бий болох магадлал хамгийн их.					

## 2.7. Төслийн үйл ажиллагаанаас нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөө

Хүснэгт 9. Нийгэм-эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Эерэг нөлөөллийн үр дагавар		
	Бага	Дунд	Их
Шинээр ажлын байр бий болох		х	
Улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх		х	
Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх		х	
Татварын орлого өсөх		х	
Орон нутгийн замын дэд бүтэц		х	
Эерэг нөлөөллийн нийт үр дагавар “их” гэсэн ангилалд хамаарч байгаа тул орон нутгийн сайжруулсан шороон зам барих ажиллагаанаас улс орны нийгэм-эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийн үр дагавар өндөр байна.			

## Төслийн үед байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийн нэгтгэл

Байгалийн хам бүрдлүүдэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны Сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг магадлан жагсаах аргаар үнэлсэн.

Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших “Цагаан элгэн” ХХК-ийн төслийн зүгээс байгаль орчин ба нийгмийн байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойллоо.



Сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо Леопальд матриц болон магадлан жагсаах аргуудыг ашигласан бөгөөд экспертийн мэдээллийг тусгаж өгсөн болно. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийн нэгдсэн үнэлгээг агаар чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг, амьтны аймаг гэсэн байгалийн үндсэн бүрэлдэхүүнүүдээр авч үзлээ.

Хүснэгт 10. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

дд	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Хөрс хуулах			Үр дүн	Дэд бүтэц				Үр дүн	Нийт дүн
		Хөрс хуулах	Хөрс тээвэрлэх	Овоолго үүсгэх		Уурхайн суурин	Уурхайн гадаад зам	Засварын талбай	Хог хаягдал		
1	Агаарын чанар	4	3	3	10	2	2	3	2	9	38
2	Газрын хэвлий	4	2	2	8	2	2	3	2	9	34
3	Хөрсөн бүрхэвч	3	0	3	6	2	2	3	2	9	31
4	Гадаргын ус	0	0	0	0	0	0	0	0	0	0
5	Газрын доорх ус	1	1	1	3	1	1	0	2	5	16
6	Ургамалан нөмрөг	4	3	2	9	3	3	4	2	12	42
7	Амьтны аймаг	2	2	2	6	2	2	2	2	8	28
<b>Нийлбэр дүн</b>		18	11	13	42	12	12	15	15	52	

Дээрх үнэлгээний хүснэгтээс төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрдэл хэсгүүдэд хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хэсэг нь агаар орчин, усан орчин, ургамалан нөмрөг, хөрс бүрхэвч болно. Уурхайн үйл ажиллагаа явагдах үед олборлолтын үйл ажиллагаанаас хөрс, газрын гадарга эвдрэх, алт угаан баяжуулахад ихээхэн ус хэрэглэх учраас гүний усны нөөцөд нөлөөлөх нь гол сөрөг нөлөөлөл гэж үзэж байна.

### 3.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

#### Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших “Цагаан элгэн” нэртэй хайлуур жоншны ордын 1,2-р биетийн хойд хэсгийг далд уурхайн аргаар ашиглах” төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ- ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

#### Хүснэгт 11. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	6 025.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 185.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	300.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700.0
5	Нөхөн сэргээлт, хаалтын зардал	-
6	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	6 000.0
7	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	140.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
<b>Нийт зардал</b>		<b>14 350.0</b>

3.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>АГААРЫН ЧАНАР</b>									
1		Зам талбайг усалж байх	Уурхайн зам	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2024 он		“Агаарын тухай”, “Агаарын бохирдлын тухай төлбөрийн тухай” хууль MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
2	Тэсэлгээ, тээвэрлэлт, хөрсний овоолгоос үүсэх тоосжилт  Хорт хийн ялгарал	Хүдэр ачсан машинуудад шороо хийсэхээс сэргийлэн ачааг хучаас материалаар хучиж	Тээврийн авто машин	тогтмол	1800.0	1	1800.0	2024 он	
<b>Нийт</b>						<b>1800.0</b>			
<b>ГАЗРЫН ГАДАРГА ХЭВЛИЙД</b>									
3	Газрыг үр ашиггүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах	Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2024 он	“Газрын тухай” хууль “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль: “Газрын хэвлийн тухай” хууль MNS 5924:2008 “Нүхэн жорлон, угаадасны нүх”-ийн ерөнхий шаардлага	
4		Ариун цэврийн байгууламж байгуулах	Төслийн талбайд	удаа	2000	1	2000.0		2024 он
<b>Нийт</b>						<b>2000.0</b>			
<b>ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>									
5	Хөрсний бүтцэд гарсан өөрчлөлт	Хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах	Хуулсан шимт хөрс	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2024 он	Газрын тухай хууль MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт”	
<b>Нийт</b>						<b>-</b>			

ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС									
6	Унд ахуйн ус бохирдох	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Унд ахуйн ус	удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан			2024 он	(MNS 4943-2015) Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай. Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.
7		Цэвэр ус нөөцлөх зориулалтын сав худалдан авч ашиглах	Унд ахуйн ус		1500.0	1	1500.0	2024 он	
<b>Нийт</b>					<b>1 500.0</b>				
УРГАМЛАН НӨМРӨГ									
8	Мод тарих	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Иххэт сумын ЗДТГ-тай ярилцаж, тохиромжт ой газар	150 ширхэг	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024 он	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ны өдрийн 58-р зарлиг
АМЬТНЫ АЙМАГ									
9	Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх	Шувуу үргээгч суурилуулах	Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн бүс	удаа	145 төг	5	725.0	2024 он	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
<b>Нийт</b>					<b>940.0</b>				
<b>Нийт зардал:</b>					<b>6 025.0</b>				

### 3.2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2024 онд олборлолтын үйл ажиллагаа явагдах тул нөхөн сэргээлт хийхгүй болно.

### 3.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:

Хүснэгт 13. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нөхөн сэргээлт хийх	Уул уурхайн олборлолтын улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх	Иххэт сумын нутаг	1	6 000.0	6 000.0	2024 он	БОНБУ-ний тухай хууль,  ЗГ 2013 оны 374-р тогтоол Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
Нийт зардал мян. төг					6 000.0		

### 3.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

### 3.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа хийгдэхгүй болно.

### 3.6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>Байгалийн аюул гамшиг</b>							
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшигийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж	Төслийн талбайн ойр орчимд		Үйл ажиллагааны зардал тусгагдсан		2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)

гаргах		Галын аюул						
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл	1	500	500.0	2024 он	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	
	Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих (www.achhold-ing.mn)	Галын аюул эрсдэл	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага	
<b>Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар</b>								
Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2024 он	MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага”	
	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	Төслийн талбайд	1	185.0	185.0	2024 он	MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”	
	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”	
	Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Төслийн талбайд	100.0	5	500.0	2024 он	MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”	
	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
<b>Нийт дүн</b>				<b>1 185.0</b>				

3.7.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	удаа	100.0	5	500.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль; “Ариун цэврийн тухай” хууль; БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тэвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тэвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх		Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024 он	
Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	Энгийн хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024 он	
	Хаягдал бохир усыг “Ирвэс Интёртрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж бие засах газар луу зайлуулах	Ариун цэврийн байгууламж	удаа	50.0	4	200.0	2024 он	
	Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын тогтоосон цэгт зайлуулж байх	Төслийн талбайд	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024 он	
Аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батарей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Аюултай хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2024 он	
<b>Нийт зардал мян. төг</b>						<b>700.0</b>		

### 3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанар</b>						
CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> Тоос нийт (PM10, PM2.5)	Төслийн талбайд орчим-1 цэг	Жилд 2 удаа	1 цэгт 2 удаа	50,000 төг*2удаа	100.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага MNS 6768 : 2019 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Дуу шуугиан хэмжээ	Төслийн талбай орчимд-1 цэг		1 цэгт 2 удаа	25,000 төг*2удаа	50.0	
<b>Хөрс</b>						
Хөрсний агрохимийн үзүүлэлт	Төслийн талбайн эрүүл газрын хөрснөөс-1цэг	Жилд 1 удаа	1 цэгт 1удаа	25,000төг*1удаа	25.0	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хог хаягдлын цэг-1	Жилд 1 удаа /дулааны улиралд/	1 цэгт 1 удаа	25,000 төг*1удаа	25.0	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Төслийн талбайн ил гарсан хөрснөөс	Жилд 2 удаа	1 цэгт 2 удаа	25,000 төг*2удаа	50.0	
<b>Усны чанар</b>						
Физик шинж чанар Химийн найрлага	Унд ахуйн ус-1 цэг	Жилд 2 удаа	21цэгт 2 удаа	25,000 төг*2удаа	50.0	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус.
<b>Нийт зардал мян. төг</b>					<b>300.0</b>	



### 3.9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		1 улирал	2 улирал	3 улирал	4 улирал		
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээний үнийн дүнгээр					БО-ны мэргэжилтэн	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох					Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ –нд хүргэж баталгаажуулах. /Тухайн жилийн БОМТ/	Уурхайн дотоод төлөвлөлтөөр					Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. /БОМТ-ний биелэлтийн тайлан/	Уурхайн дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр					БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
<b>Нийт зардал мян. төг</b>		-					

**1.10. Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх**

**Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.** Тус төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр Сумын удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

*Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь*

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	-	БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд	Хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар - Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах болон бусад мэдээллийг	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	Үйл ажиллагааны менежер	Дүүрэг, хорооны иргэдийн хуралд
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар	Тухай бүрд	-	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газарт
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	Тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	Тухай бүрд	140.0	БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Иргэдэд
<b>Нийт зардал мян. төг</b>				<b>140.0</b>		

БОМТ-ний биелэлтийн тайланг тухайн оны 11-р сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлэх ба үүнээс өмнө хуваарийн дагуу нөлөөллийн бүсийн оршин суугчдад, сонирхогч талуудад төслийн талаар танилцуулж, тайлагнах ажиллагааг зохион байгуулсан байна.